



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 2/13

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Захиргааны ерөхний хуулийн 43, 46 дугаар зүйл, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвд 2026 онд нормын хувцас зөөлөн эдлэл нийлүүлэх тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Аззаяа (Сургалт хөгжил бодлого төлөвлөлт гүйцэтгэлийн албаны дарга)

Нарийн бичиг: Э.Түмэнжаргал (Эдийн засагч)

Гишүүд: Ц.Лувсандамдин (Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга)

Ч.Ганцэцэг (Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан төрийн бус байгууллагын өвөрхангай аймаг дахь салбарын зохицуулагч)

Т.Энхтайван (Иргэний төлөөлөл)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Д.Аззаяа)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН